



Ор хонгог тулмын хэвлэл  
Оны 10 дугаар сарын 20  
№39 /660/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын  
Ерөнхийлөгчийн  
зарлиг

1585

Монгол Улсын  
Засгийн газрын  
тогтоол

1589

Монгол Улсын  
Дээд шүүхийн  
тогтоол

1598

Монгол Улсын Гавъяат хуульч  
цол хүртээх тухай

Журам батлах тухай

Иргэний хуулийн 5, 6, 7  
дугаар бүлгийн зарим зүйл,  
заалтыг тайлбарлах тухай

## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

331. Монгол Улсын Гавъяат хуульч цол хүртгэх тухай Дугаар 180 1585

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

332. Мал аж ахуйн салбарын 2010-2011 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай Дугаар 166 1586

333. Журам батлах тухай Дугаар 172 1589

### МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

334. Иргэний хуулийн 5, 6, 7 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай Дугаар 17 1598

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2010 оны 08 дугаар Дугаар 180 Улаанбаатар  
сарын 03-ны өдөр хот

#### Монгол Улсын Гавъяат хуульч цол хүртгэх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь.

Монгол Улсад прокурорын байгууллага үүсч хөгжсөний 80 жилийн ойг тохиолдуулан прокурорын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажилласан дараах хүмүүст Монгол Улсын Гавъяат хуульч цол хүртээсүгэй.

1. Түмэнгийн Жадамбаа - Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор

2. Бат-Очирын Цэрэнбалтав - Улсын Ерөнхий прокурорын орлогч

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2010 оны 7 дугаар  
сарын 7-ны өдөр

Дугаар 166

Улаанбаатар  
хот

**Мал аж ахуйн салбарын 2010-2011 оны  
өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах  
зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Цаг агаарын хүндрэл, гамшгийн үед хэрэглэх зорилгоор бүрдүүлэх аймаг, нийслэл, сум, дүүргийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийн хэмжээг хавсралт ёсоор баталсугай.

2. Сүүлийн өдрүүдэд агаарын температур өссөнтэй холбогдуулан хөрс, агаар хэт халж, тариа, бэлчээр гандах төлөвтэй байгааг харгалзан цаг агаарт зориудаар нөлөөлж хур тундас оруулах ажлын цар хүрээг нэмэгдүүлэх, малыг зуны оторт гарган таргалуулах, шаардлагатай газарт гангийн зэрэглэл тогтоох зэрэг арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, Байгаль орчин, аялал, жуулчлалын сайд Л.Гансүх, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Мал сүргээ өөрийн нутаг, орон нутгийн отрын бэлчээрт болон гэрээ байгуулж бусад аймаг, сумдын нутагт отор нүүдлээр өвөлжүүлэх хуваарь гарган энэ оны 9-10 дугаар сард багтаан отор нүүдлийг зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, тусгай хамгаалалттай газар болон аймаг дундын отрын бэлчээрт өвөлжүүлэх өрх, малын тоог аймгийн удирдлагатай хамтран тохирч, зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, Байгаль орчин, аялал, жуулчлалын сайд Л.Гансүх, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга нарт тус тус даалгасугай.

4. Дараахь арга хэмжээг авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай:

а) ОХУ-аас тусламжаар өгсөн арвайгаар тэжээл үйлдвэрлэх болон хадлан, тэжээл бэлтгэх замаар энэ тогтоолын хавсралтаар баталсан өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх, байршуулах зохион байгуулалтын арга хэмжээ авах;

б) мал өвөлжилтийн бэлтгэл хангах чиглэлээр нутгийн захиргааны байгууллагын зүгээс зохион байгуулах үйл ажиллагаа болон малчид, мал бүхий иргэдийн хийх тодорхой ажлыг хамруулсан төлөвлөгөөг



аймаг, нийслэл, сум, дүүрэг бүрээр баталж, хэрэгжилтийг зохион байгуулан дүнг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хурлаар хэлэлцүүлж, мал өвөлжүүлэх, хаваржуулах төлөвлөгөөний хамт Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд тайлагнах;

в) малын халдварт болон паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга, угаалга, туулга зэрэг арга хэмжээг технологийн дагуу цаг хугацаанд нь хийлгэх болон өвөлжөө, хашаа, хорооны ариутгал, халдааргүйтгэлийн ажлын явцад хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллах;

г) хадлангийн болон тэжээл үйлдвэрлэх техникийн засвар үйлчилгээний ажлыг энэ оны 7 дугаар сарын 20-ны дотор дуусгаж, хадлангийн техникээр үйлчлэх ажлыг зохион байгуулж ажиллах;

д) 2011 оны хаврын улиралд нийслэл, аймгийн төвийн хүн амын махны хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор мал бэлтгэж, махыг үйлдвэрийн аргаар боловсруулан нөөцлөх, дотоодын болон гадаадын зах зээлд нийлүүлэх арга хэмжээг холбогдох байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран зохион байгуулах;

е) хээлтүүлэгч малын тооцоог гаргаж, дутагдалтай байгаа хээлтүүлэгчийг нөхөн тавиулах, худалдан борлуулах, малчид, иргэдийн захиалгын дагуу малын зохиомол хээлтүүлгийг зохион байгуулах;

ж) бэлчээр, хадлангийн талбай хаших, уст цэг гаргах, хадлан хадах, тэжээл бэлтгэх, түүхий эд боловсруулах, ахуйн үйлчилгээ үзүүлэх, малын удмын санг хамгаалах, малыг эрүүлжүүлэх зэрэг малчдад туслах чиглэлийн жижиг үйлчилгээг хөгжүүлэх ажлыг зохион байгуулах;

з) өвөлжилт хүндэрсэн нөхцөлд малчдад үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээнд шаардагдах шатахуун болон шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх арга хэмжээ авах;

и) өвөлжилтийн бэлтгэл хангах ажлыг хангалтгүй зохион байгуулж байгаа сум, дүүргийн удирдлага, албан тушаалтантай хариуцлага тооцон ажиллах.

5. Дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунайд даалгасугай:

а) "Төрөөс малчдын талаар баримтлах бодлого", "Монгол мал" үндэсний хөтөлбөрийг малчид болон иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх;

б) өвөлжилтийн бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөг салбарын хэмжээнд гарган хэрэгжүүлэх арга хэмжээг холбогдох яам, газар, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгуулан, өвөлжилтийн бэлтгэл хангах ажлыг хангалтгүй зохион байгуулсан аймаг, нийслэлийн удирдлага, албан тушаалтантай тодорхой хариуцлага тооцон ажиллах;

в) хадлан болон тэжээл бэлтгэх техник, тоног

төхөөрөмжийг салбарын хэмжээнд хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хүрээнд нэмэгдүүлэх, тэргүүний үйлдвэрлэгч, хадланчдыг урамшуулах болзол зарлаж, тэдгээрийн туршлага, үр дүнг нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах;

г) үтрэмийн талбай, агуулахаас гарч байгаа тэжээлийн будаа, үр тарианы сүрэл, төмс, хүнсний ногооны иш, навч зэргийг малын тэжээл бэлтгэхэд ашиглах талаархи мэргэжлийн байгууллага, эрдэмтэн, мэргэжилтнүүдийн заавар, зөвлөгөөг нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах.

6. Мал өвөлжилтийн бэлтгэл хангах ажилд шаардлагатай хөрөнгийг төсвийн багцынхаа хүрээнд зохицуулж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунайд даалгасугай.

7. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж, мал өвөлжилтийн бэлтгэл ажлын дүнг улсын хэмжээгээр нэгтгэн 2010 оны 11 дүгээр сард багтаан Засгийн газарт танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунайд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН  
ҮЙЛДВЭРИЙН САЙД**

**Т.БАДАМЖУНАЙ**

Засгийн газрын 2010 оны 166 дугаар  
тогтоолын хавсралт

**ЦАГ АГААРЫН ХҮНДРЭЛ, ГАМШГИЙН ҮЕД ХЭРЭГЛЭХ  
ЗОРИЛГООР БҮРДҮҮЛЭХ АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ,  
ДҮҮРГИЙН ӨВС, ТЭЖЭЭЛИЙН АЮУЛГҮЙН  
НӨӨЦИЙН ХЭМЖЭЭ**

№	Аймгийн нэр	Аймаг, нийслэлийн аюулгүйн нөөц		Сум, дүүргийн аюулгүйн нөөц	
		Өвс /тн/	Тэжээл /тн/	Өвс /тн/	Тэжээл /тн/
1	Архангай	1700	750	200	150
2	Баян-Өлгий	1200	500	100	80
3	Баянхонгор	400	300	50	50
4	Булган	1800	750	200	150
5	Говь-Алтай	400	300	50	50
6	Говьсүмбэр	200	200	50	50
7	Дархан-Уул	1500	500	200	150



8	Дундговь	500	300	50	50
9	Дорноговь	300	300	50	50
10	Дорнод	1350	500	100	70
11	Завхан	1400	600	100	80
12	Орхон	1500	500	200	120
13	Өвөрхангай	1200	400	100	70
14	Өмнөговь	400	300	50	50
15	Сэлэнгэ	1800	1000	200	150
16	Сүхбаатар	1200	400	100	70
17	Төв	1350	500	100	70
18	Увс	1500	750	150	100
19	Ховд	1500	1000	150	120
20	Хөвсгөл	1500	750	200	120
21	Хэнтий	1350	500	100	70
22	Улаанбаатар	400	500	50	50
	Дүн	24450	11600	-	-

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 7 дугаар  
сарын 7-ны өдөр

Дугаар 172

Улаанбаатар  
хот

### Журам батлах тухай

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5.2, 7.1-ийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавъяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаяр, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 1998 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 234 дүгээр тогтоол, "Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2004 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн 163 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААНЫ САЙД

Ё.ОТГОНБАЯР



Засгийн газрын 2010 оны 172 дугаар  
тогтоолын хавсралт

**ТҮҮХЭН ҮЙЛ ЯВДЛЫН ОЙ, ТЭМДЭГЛЭЛТ ӨДРИЙГ ТЭМДЭГЛЭХ,  
ГАВЪЯАТ ҮЙЛСТНИЙГ АЛДАРШУУЛАХ, ДУРСГАЛЫГ НЬ  
МӨНХЖҮҮЛЭХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдээс бусад улс, салбар, орон нутгийн чанартай түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх болон гавъяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх ажлыг зохион байгуулахад энэхүү журмыг мөрдөнө.

Хоёр. Түүхэн үйл явдлын ой

2.1. Монгол Улсын түүхэнд холбогдох дараахь онцгой үйл явдлын ойг дор дурдсан хугацаанд тэмдэглэнэ:

2.1.1. Хүннү гүрэн байгуулагдсаны ойг Цагаан сар-билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгний өдөр;

2.1.2. Эзэн богд Чингис хааны мэндэлсний ойг “Үндэсний Бахархлын өдөр” болгон жил бүр 5 дугаар сарын 31-ний өдөр;

2.1.3. Их Монгол Улс байгуулагдсаны ойг жил бүр Ардын хувьсгалын ой-Үндэсний их баяр наадмын өдөр;

2.1.4. 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгалын ойг жил бүр 12 дугаар сарын 29-ний өдөр;

2.1.5. 1990 оны Ардчилсан хувьсгалын ойг жил бүр 12 дугаар сарын 10-ны өдөр;

2.1.6. салбарыг 100 болон түүнээс дээдэлн 50 жилийн давтамжтай их тэгш ойг тухайн салбарын үүсэж байгуулагдсан өдөр.

2.2. Дараахь түүхэн үйл явдлын ойг дор дурдсан хугацаанд 10 жилийн давтамжтай тэмдэглэнэ:

2.2.1. Халх голын байлдааны ялалтын ойг 8 дугаар сард;

2.2.2. Дэлхийн II дайн дууссаны болон 1945 оны чөлөөлөх дайны ялалтын ойг 8 дугаар сард;

2.2.3. Монгол Улсын баруун хил дээр 1948 онд болсон

зэвсэгт тулгаралт дууссаны ойг 6 дугаар сард;

2.2.4. Монгол хүн сансарт ниссэний болон сансрын хамтарсан нислэгийн ойг 3 дугаар сард.

Гурав. Түүхэн үйл явдлын ойг тэмдэглэх

3.1. Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хороо энэ журмын 2.1.1-2.1.6-д заасан ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, төсвийн төслийг боловсруулж, Засгийн газарт оруулж шийдвэрлүүлнэ.

3.2. Батлан хамгаалахын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага энэ журмын 2.2.1-2.2.4-т заасан ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, төсвийн төслийг боловсруулж, Засгийн газарт оруулж шийдвэрлүүлнэ.

3.3. Орон нутгийн байгууллагын 50 болон түүнээс дээшхи 10 жилийн давтамжтай тэгш ойг тэмдэглэх асуудлыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шийдвэрлэнэ.

3.4. Энэ журмын 3.3-т зааснаас бусад байгууллага болон тодорхой салбарын 50 болон түүнээс дээшхи 10 жилийн давтамжтай тэгш ойг тэмдэглэх асуудлыг тухайн салбарын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.

3.5. Олон улсын хэмжээний түүхэн үйл явдлын тэгш, их тэгш ойг тэмдэглэх асуудлыг гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага судлан үзэж, шаардлагатай гэж үзвэл Засгийн газарт оруулж шийдвэрлүүлнэ.

3.6. Онцгой болон түүхэн үйл явдлын ойг тэмдэглэх ажлын хүрээнд дараахь арга хэмжээг зохион байгуулж болно:

3.6.1. түүхэн үйл явдлын агуулга, мөн чанар, ач холбогдол, сургамжийг олон нийтэд танин мэдүүлж, сурталчлах;

3.6.2. түүхэн үйл явдалтай холбогдуулан шинжлэх ухааны тодорхой салбар, чиглэлээр эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах;

3.6.3. уралдаан, тэмцээн, наадам, үзлэг, өдөрлөг, спартакиад, аялал зэрэг соёл, урлаг, спортын арга хэмжээ зохион байгуулах;

3.6.4. ном, кино бүтээх;





### 3.6.5. хөшөө, дурсгалын самбар, багана босгох.

3.7. Хөшөө, дурсгалын самбар, баганын загвар, түүний тодорхойлолтыг барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын гаргасан мэргэжлийн дүгнэлтийг үндэслэн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна.

3.8. Ойг тэмдэглэхэд шаардагдах хөрөнгийг тухайн жилийн улсын болон орон нутгийн төсөвт тусган батлуулна. Ойг тэмдэглэх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн тодорхой хэсгийг иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын хандив, ивээн тэтгэгчдийн хөрөнгөөр санхүүжүүлж болно.

### Дөрөв. Тэмдэглэлт өдөр

4.1. Салбарын хэмжээнд дараахь тэмдэглэлт өдрийг дор дурдсан хугацаанд тэмдэглэнэ:

4.1.1. Иргэний нийгмийн өдөр-жил бүрийн 1 дүгээр сарын 31-ний өдөр;

4.1.2. Багш нарын өдөр-жил бүрийн 2 дугаар сарын эхний Ням гараг;

4.1.3. Хөдөлмөр, нийгмийн халамжийн ажилтны өдөр-жил бүрийн 2 дугаар сарын хоёр дахь Ням гараг;

4.1.4. Хэвлэл, мэдээллийн ажилтны өдөр-жил бүрийн 3 дугаар сарын 6-ны өдөр;

4.1.5. Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах өдөр-жил бүрийн 3 дугаар сарын 15-ны өдөр;

4.1.6. Наурызын баяр-жил бүрийн 3 дугаар сарын 22-ны өдөр;

4.1.7. Усны өдөр-жил бүрийн 3 дугаар сарын 23-ны өдөр;

4.1.8. Хөнгөн, хүнсний аж үйлдвэр, худалдааны ажилтан, ажилчдын өдөр-жил бүрийн 3 дугаар сарын 26-ны өдөр;

4.1.9. Мод тарих өдөр-жил бүрийн 4 дүгээр сарын хоёр дахь Ням гараг;



4.1.10. Үндэсний бичиг үсгийн баяр-жил бүрийн 5 дугаар сарын эхний Ням гараг;

4.1.11. Газрын харилцааны ажилтны өдөр-жил бүрийн 5 дугаар сарын эхний Ням гараг;

4.1.12. Байгаль хамгаалах өдөр-жил бүрийн 5 дугаар сарын 2 дахь Ням гараг;

4.1.13. Газрын тосны салбарын ажилтны өдөр-жил бүрийн 5 дугаар сарын 4 дэх Ням гараг;

4.1.14. Иргэний агаарын тээвэрчдийн өдөр-жил бүрийн 5 дугаар сарын 4 дэх Ням гараг;

4.1.15. Бурхан багшийн их дүйцсэн өдөр-билгийн тооллын зуны эхэн сарын арвантавны өдөр;

4.1.16. Мэргэжлийн хяналтын ажилтны өдөр-жил бүрийн 6 дугаар сарын 2 дахь Ням гараг;

4.1.17. Онцгой байдлын албаны өдөр-жил бүрийн 6 дугаар сарын 20-ны өдөр;

4.1.18. Хуульчдын өдөр-жил бүрийн 6 дугаар сарын 4 дэх Ням гараг;

4.1.19. Тамирчдын өдөр-жил бүрийн 6 дугаар сарын 4 дэх Ням гараг;

4.1.20. Хоршоологчдын өдөр-жил бүрийн 7 дугаар сарын эхний Ням гараг;

4.1.21. Цагдаагийн болон Дотоодын цэрэг, Тагнуулын байгууллагын өдөр-жил бүрийн 7 дугаар сарын 19-ний өдөр;

4.1.22. Авто тээвэрчдийн өдөр-жил бүрийн 7 дугаар сарын 3 дахь Ням гараг;

4.1.23. Шууданч, холбоочдын өдөр-жил бүрийн 7 дугаар сарын 4 дэх Ням гараг;

4.1.24. Төмөр замчдын өдөр-жил бүрийн 8 дугаар сарын эхний Ням гараг;



4.1.25. Эрүүл мэндийн салбарын ажилтны өдөр-жил бүрийн 8 дугаар сарын хоёр дахь Ням гараг;

4.1.26. Эрчим хүчний ажилтны өдөр-жил бүрийн 8 дугаар сарын 3 дахь Ням гараг;

4.1.27. Соёл, урлагийн ажилтны өдөр-жил бүрийн 9 дүгээр сарын 2 дахь Ням гараг;

4.1.28. Аялал, жуулчлалын өдөр-жил бүрийн 9 дүгээр сарын 27-ны өдөр;

4.1.29. Үндэсний татварын ажилтны өдөр-жил бүрийн 9 дүгээр сарын 2 дахь Ням гараг;

4.1.30. Барилгачдын өдөр-жил бүрийн 9 дүгээр сарын эхний Ням гараг;

4.1.31. Хилчдийн өдөр-жил бүрийн 9 дүгээр сарын 17-ны өдөр;

4.1.32. Оюутны өдөр-жил бүрийн 10 дугаар сарын 5-ны өдөр;

4.1.33. Нийтийн аж ахуй, ахуйн үйлчилгээний ажилтны өдөр-жил бүрийн 10 дугаар сарын 2 дахь Ням гараг;

4.1.34. Стандарт, хэмжил зүйн ажилтны өдөр-жил бүрийн 10 дугаар сарын 14-ний өдөр;

4.1.35. Гаалийн ажилтны өдөр-жил бүрийн 10 дугаар сарын 20-ны өдөр;

4.1.36. Геологичдын өдөр-жил бүрийн 10 дугаар сарын 3 дахь Ням гараг;

4.1.37. Авто замчдын өдөр-жил бүрийн 10 дугаар сарын 4 дэх Ням гараг;

4.1.38. Хөдөө аж ахуйн ажилтны өдөр-жил бүрийн 11 дүгээр сарын 2 дахь Ням гараг;

4.1.39. Шинжлэх ухааны ажилтны өдөр-жил бүрийн 11 дүгээр сарын 4 дэх Ням гараг;



4.1.40. Архивчдын өдөр-жил бүрийн 12 дугаар сарын 5-ны өдөр;

4.1.41. Санхүү, эдийн засагчдын өдөр-жил бүрийн 12 дугаар сарын 2 дахь Ням гараг;

4.1.42. Уурхайчдын өдөр-жил бүрийн 12 дугаар сарын 25-ны өдөр;

4.1.43. Дипломат албаны өдөр-жил бүрийн 12 дугаар сарын 29-ний өдөр.

#### Тав. Тэмдэглэлт өдрийг тэмдэглэх

5.1. Салбарын болон зарим ажил мэргэжлийн ажилтан, ажилчдын өдрийг тэмдэглэх нь тухайн салбарын ололт амжилтыг олон нийтэд мэдээлж сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, харилцан туршлага солилцох, иргэдэд үйлчилгээ үзүүлэх, тэдний санал, хүсэлтийг сонсож, бүтээлч ажил, үйл ажиллагаанд оролцуулах, ажилтан ажилчдын хөдөлмөр, бүтээлийг тодруулан алдаршуулах зорилго агуулна.

5.2. Тэмдэглэлт өдрийг тэмдэглэх асуудлыг тухайн байгууллага үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөвтөө тусган батлуулж, зардлын гүйцэтгэлд нь хяналт тавина.

5.3. Тэмдэглэлт өдрийг тэмдэглэх үеэр баярын болон эрдэм шинжилгээний хурал, цуглаан, уулзалт хийх, хөдөлмөрийн алдарт тэмдэглэх, шагнаж урамшуулах, туршлага солилцох, үдэшлэг, өдөрлөг, оюун ухаан сорих болон биеийн тамирын тэмцээн, ажил, мэргэжлийн уралдаан зохиох, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах зэрэг ажил зохион байгуулж болно.

5.4. Тэмдэглэлт өдрийг тухайн жилд бүтээлч ажлын хөдөлгөөн өрнүүлэн тодорхой сэдэв, уриан дор зохион байгуулж болно.

5.5. Тэмдэглэлт өдрийг тогтоосон хугацаанд тэр дэглэж, үр дүнг тооцож ажиллана.

#### Зургаа. Гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх

6.1. Гавьяат үйлстэнд дор дурдсан хүмүүсийг хамруулна:

6.1.1. Монгол Улсын баатар;

6.1.2. Монгол Улсын хөдөлмөрийн баатар;

6.1.3. Монгол Улсын ардын цолтон;

6.1.4. Монгол Улсын гавьяат цолтон;

6.1.5. Монгол Улсын Төрийн шагналтан.

6.2. Гавьяат үйлстэн мэндэлсний 70 болон түүнээс дээшхи 10 жилийн давтамжтай тэгш ойг нь тохиолдуулан тодорхой байгууллагыг түүний нэрэмжит болгож болно.

6.3. Орон нутгийн байгууллагыг гавьяат үйлстний нэрэмжит болгох, урьд нь нэрэмжит болгосон шийдвэрийг өөрчлөх санал хүсэлтийг сум, дүүргийн Засаг дарга судлан үзэж, энэхүү журамд нийцэж байгаа тохиолдолд аймаг, нийслэлийн Засаг даргад дараахь баримт бичгийн хамт жил бүрийн I улиралд багтаан хүргүүлнэ:

6.3.1. нэрэмжит болгох, урьд нь нэрэмжит болгосон шийдвэрийг өөрчлөх үндэслэл;

6.3.2. гавьяат үйлстний намтар;

6.3.3. хүсэлт гаргасан байгууллагын танилцуулга, хамт олны хурлын тэмдэглэл;

6.3.4. сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын санал.

6.4. Аймаг, нийслэлийн Засаг дарга нь энэ журмын 6.3-т заасан санал, хүсэлт, баримт бичгийг хүлээн авч хянан үзэж 30 хоногийн дотор хариу өгөх буюу шийдвэрийн төсөл боловсруулж, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулж шийдвэрлүүлнэ.

6.5. Энэ журмын 6.3-т зааснаас бусад байгууллагыг гавьяат үйлстний нэрэмжит болгох, урьд нь нэрэмжит болгосон шийдвэрийг өөрчлөх санал хүсэлтийг тухайн асуудлыг хариуцсан төрийн захиргааны төв байгууллага судлан үзэж, энэхүү журамд нийцэж байгаа тохиолдолд соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад дараахь баримт бичгийн хамт жил бүрийн I улиралд багтаан хүргүүлнэ:

6.5.1. нэрэмжит болгох, урьд нь нэрэмжит болгосон шийдвэрийг өөрчлөх үндэслэл;

6.5.2. гавьяат үйлстний намтар;



6.5.3. хүсэлт гаргасан байгууллагын танилцуулга, хамт олны хурлын тэмдэглэл;

6.5.4. тухайн ажлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүний санал, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын санал.

6.6. Энэ журмын 6.5-д санал, хүсэлт, баримт бичгийг соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хянан үзэж, энэхүү журмын шаардлагад нийцэж байгаа тохиолдолд шийдвэрийн төсөл боловсруулж, Засгийн газарт оруулан шийдвэрлүүлнэ.

6.7. Байгууллагыг гадаад орны төр, нийгмийн зүтгэлтэн, гавъяат үйлстний нэрэмжит болгох асуудлыг гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн энэхүү журмын дагуу шийдвэрлэнэ.

6.8. Гавъяат үйлстний нэрэмжит болсон байгууллага нь гавъяат үйлстний үйл хэргийг мөнхжүүлэн нэр төртэй авч явах бөгөөд түүний гэр бүл, үр хүүхэдтэй холбоотой байж, харилцан дэмжлэг туслалцаа үзүүлж болно.

6.9. Гавъяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх зорилгоор түүний мэндэлсний 100 болон түүнээс дээшхи 50 жилийн давтамжтай их тэгш ойг тэмдэглэнэ. Ой тэмдэглэх тухай санал хүсэлтийг тухайн салбарын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг дарга судалж, шаардлагатай гэж үзвэл соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад дараахь баримт бичгийн хамт жил бүрийн I улиралд багтаан хүргүүлнэ:

6.9.1. гавъяат үйлстний тухай дэлгэрэнгүй танилцуулга, түүний ойг тэмдэглэх үндэслэл;

6.9.2. ойг тэмдэглэх ажлын төлөвлөгөө, төсвийн төсөл, санхүүжилтийн эх үүсвэрийн талаархи мэдээлэл.

6.10. Соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага дээрх санал хүсэлтийг хүлээн авч судлан, шаардлагатай гэж үзвэл шийдвэрийн төсөл боловсруулж Засгийн газарт оруулан шийдвэрлүүлнэ.

6.11. Гавъяат үйлстний дурсгалд зориулсан самбар, багана, суварга, цээж баримал, хөшөө босгох, гэр музей, цэцэрлэгт хүрээлэн байгуулах, гудамж, талбайг гавъяат үйлстний нэрэмжит болгох, ой

тэмдэглэх асуудлыг аймаг, нийслэлийн Засаг дарга судлан иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хэлэлцүүлж, тухайн жилийн төсөвтөө багтаан шийдвэрлэнэ.

### Долоо. Бусад

7.1. Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх болон гавъяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх саналыг байгууллага, аж ахуйн нэгжийн хамт олны хурлаас өмчийн хэлбэр харгалзахгүйгээр гаргаж болно.

7.2. Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх болон гавъяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэхэд шаардагдах төсөв батлагдаагүй, төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэр гараагүй тохиолдолд уг үйл ажиллагааг санхүүжүүлсэн бол зарцуулсан хөрөнгийг тухайн төсөвт байгууллагын шийдвэр гаргасан албан тушаалтнаар нөхөн төлүүлж төсөвт төвлөрүүлнэ.

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2010 оны 06 дугаар  
сарын 22-ны өдөр

Дугаар 17

Улаанбаатар  
хот

### ИРГЭНИЙ ХУУЛИЙН 5, 6, 7 ДУГААР БҮЛГИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Иргэний хуулийн "Хэлцэл" 3 дугаар дэд хэсгийн нийтлэг үндэслэл, хүчин төгөлдөр бус хэлцэл, төлөөллийг зохицуулсан 5, 6, 7 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд Шүүхээс **ТОГТООХ НЬ:**

**Нэг. Хэлцэлт хийх хүсэл зоригийг илэрхийллийг тодорхойлсон Иргэний хуулийн (цаашид хууль гэх) 39, 40, 41 дүгээр зүйлийн зарим заалт, хэсгийг доорх байдлаар тайлбарласугай.**

1.1. Хуулийн 39-41 дүгээр зүйлд заасан "хүсэл зориг" гэж тодорхой этгээдийн иргэний эрх, үүргийг үүсгэх, өөрчлөх, шилжүүлэх, дуусгавар болгох буюу хэлцэл хийх эрмэлзлэлийг хэлэх бөгөөд уг эрмэлзлэлийн гадаад илрэлийг "хүсэл зоригийн илэрхийлэл" гэж ойлговол зохино.

Хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2-т тодорхойлсон нэг этгээдийн хүсэл зоригийн илэрхийллээр хийгдсэн хэлцэл зөвхөн хуульд зааснаар эсхүл харилцан тохиролцсоноор нөгөө этгээдэд эрх, үүрэг үүсгэнэ.

1.2.Хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-д зааснаар хэлцэл хийх хүсэлтэй этгээдийн уг эрмэлзлэлээ илэрхийлсэн байдлыг нөгөө тал ойлгож, утга санааг нь ухамсарласан тохиолдолд **"хүсэл зоригийн илэрхийллийг хүлээн авсан"** гэж үзнэ. Хүсэл зоригийн илэрхийллийг хүлээж авсан явдлыг хүсэл зоригийг өөрийг нь хүлээн зөвшөөрсөн гэж ойлгохгүй.

Хэлцэл хийх эрмэлзлэлийн илрэлийг тодорхой бус буюу үндэслэлгүйгээс ойлгоогүй, эсхүл ийнхүү хүсэл зоригийг илэрхийлэхээс өмнө ойлгох боломжгүйгээ нөгөө тал мэдэгдсэн тохиолдолд хүсэл зоригийн тухайн илэрхийлэл хүчин төгөлдөр болохгүй бөгөөд энэ нь хүсэл зоригийг болон хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж үзэх үндэслэл болохгүй.

1.3.Хэлцлийн нэг тал хэлцэл хийснээс хойш нас барсан эсхүл эрх зүйн бүрэн чадамжгүй болсон бол ийнхүү нас барах, эрх зүйн чадамжгүйд тооцох тухай шүүхийн шийдвэр гарахаас өмнө хийгдсэн хэлцэл, улмаар хэлцлийг хийх хүсэл зориг хүчин төгөлдөр хэвээр байх тул хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3-т заасан **"илэрхийлсэн хүсэл зоригийн илэрхийлэл"** буюу хүсэл зоригийн нэгэнт хийгдсэн, өөрчлөх боломжгүй гадаад илрэл мөн хүчин төгөлдөр байна.

Хүсэл зоригийн илэрхийлэгч нас барсан, эрх зүйн чадамжгүй болсон явдал нь хэлцэл, хүсэл зориг, түүний илэрхийллийг хүчин төгөлдөр бус гэж үзэх үндэслэл болохгүй хэдий ч уг хэлцэл болон хүсэл зоригийн илэрхийллийг үүнээс өөр үндэслэлээр хүчин төгөлдөр бус гэж үзэхэд саад болохгүй.

Эрх зүйн бүрэн чадамжгүй болсон этгээдийн илэрхийлсэн хүсэл зориг хүчин төгөлдөр байх эсэхийг тодорхойлоход хэдий үеэс эрх зүйн чадамжгүй болсныг шүүхийн шийдвэрээр тогтоосныг харгалзан үзэхээс гадна хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.6-д заасан үндэслэлийг анхаарвал зохино.

1.4.Хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д заасан **"хүсэл зоригийн агуулга"** гэдгийг хэлцэл хийх хүсэлтэй этгээдийн эрмэлзлэлийн мөн чанар, харин мөн зүйлийн 41.2.-т заасан **"хүсэл зоригийн илэрхийллийн утга"** гэдгийг энэхүү эрмэлзлэлийн гадаад илрэлийн гол санаа гэж тус тус ойлгоно.

Хүсэл зоригийн агуулгыг тодорхойлоход үгийн г ууд утгыг, хүсэл зоригийн илэрхийллийн утгыг тодорхойлоход учир санааг гол төлөв анхаарна.

Хүсэл зоригийг үг, үйлдлээр илэрхийлэхээс гадна идэвхгүй байр сууриар илэрхийлэх боломжтой учир хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т заасан **"эс үйлдэхүй"** гэдэгт бусадтай хэлцэл хийхгүй байх, хэлцэл хийх бусдын саналд хариу өгөхгүй байх, эрх, үүргийг дуусгавар болгох талаар санал, санаачилга гаргахгүй байх, дуугүй байснаар хүлээн зөвшөөрөх зэргээр тодорхой үйлдэл хийхгүй, хийхээс татгалзахыг хамааруулан



ойлгоно.

Хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т заасан “бусад нөхцөл байдал” гэж хүсэл зоригийн илэрхийллийн утга санааг тодорхойлоход ач холбогдол бүхий аливаа хүчин зүйлийг хэлнэ.

**Хоёр.Хэлцлийн хэлбэрийн талаарх хуулийн 42 дугаар зүйлийн зарим заалт, хэсгийг дараах байдлаар тайлбарласугай.**

2.1.Уг зүйлд болон цаашид хуульд заасан “хэлцлийн хэлбэр” гэдгийг хүсэл зоригийг илэрхийлэх арга гэж ойлгох ба хэлцлийг амаар хийнэ гэдэг нь хүсэл зоригийг үгээр илэрхийлэхийг, бичгээр хийнэ гэдэг нь үгээр илэрхийлсэн хүсэл зоригийг баримт бичгийн хэлбэрт оруулахыг хэлнэ.

2.2.Энэ зүйлийн 42.2-т заасан “гарын үсэг зурснаар” гэдэгт хэлцэлд оролцогчдын хэн алины хүсэл зоригийг тусгасан нэгдсэн нэг баримтын агуулгыг хүлээн зөвшөөрснийг баталгаажуулах зорилгоор хэлцэл хийж буй эсхүл эрх бүхий этгээд өөрийн нэр болон бусад тодорхой тэмдэглэлийг уг баримтад тусгахыг ойлгоно.

2.3. Мөн зүйлийн 42.3-т заасан “ажил хэргийн хүрээнд тогтсон заншил” гэдэгт хэлцэлд оролцогчдын хооронд тогтмол хийгдэж хэвшсэн эсхүл тухайн төрлийн үйл ажиллагааг явуулахад нийтээр байнга хэрэглэж заншсан арга барилыг ойлгох ба “техникийн хэрэгслээр шууд буулгасан” гэж дүрс, зураг, электрон, цахилгаан болон цахим хэлбэрээр тухайн этгээдийн нэр болон тодорхой тэмдэглэгээг байгаа байдлаар нь хувилан гаргахыг хэлэхээс гадна технологийн шинэ ололтыг ашиглан гарын үсэг, тэмдэглэгээг тусгай пин код, нууц үг хэрэглэх зэргээр гаргахыг хамааруулж болно.

2.4.Энэ зүйлийн 42.4-т заасан “бусад этгээд” гэдэгт тухайн хэлцлийг гэрчлэх хуулиар бүрэн эрх олгогдсон этгээдийг ойлгоно.

2.5.Мөн зүйлийн 42.5-д заасан “итгэмжлүүлсэн этгээдийн гарын үсгийг баталгаажуулсан байх”, “өөр этгээдээр гарын үсэг зуруулах **Бэлгэс, шалтгасныг бичих**” шаардлагууд нь нотариатаар буюу эрх бүхий этгээдээр гэрчлүүлж буй хэлцлээс хамаарахаас гадна ийнхүү гэрчлүүлэх шаардлагагүй бичгийн хэлбэртэй хэлцэлд мөн хамаарна.

2.6.Энэ зүйлийн 42.8-д заасан “бодит үйлдэл” гэдэгт хүсэл зоригийг үгээр болон бичгээр илэрхийлээгүй ч өөрийн санааг бусдад ойлгогдохуйц аргаар илэрхийлсэн аливаа зан үйлийг хамааруулан ойлгоно.

2.7.Уг зүйлийн 42.9-д заасан “саналд хариу өгөхгүй байх” гэснийг зөвхөн хуульд заасан эсхүл талууд харилцан тохиролцсон тохиолдолд “дуугүй байх нь хүлээн зөвшөөрсний илэрхийлэл” гэх зарчимд хамааруулан үзнэ.



**2.8. "Гэрчээр нотлох эрх"-ийг хязгаарласан энэ зүйлийн 42.11 дэх заалт нь зөвхөн бичгээр хийх хуулийн шаардлага бүхий хэлцэлд, түүнчлэн хуулийн уг шаардлагыг биелүүлээгүй хэлцэл хүчин төгөлдөр бус байхаар хуульд заагдаагүй хэлцэлд тус тус хамаарна.**

Мөн зүйл, хэсэгт заасан "Нотолгооны бусад хэрэгсэл"-д Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан гэрчийн мэдүүлгээс бусдыг хамааруулан ойлгоно.

**Гурав. Хэлцэл хийгдсэн гэж үзэх хуулийн 43 зүйлийн зохицуулалтыг доорх байдлаар тайлбарласугай.**

**3.1. Хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.3-т заасан "ердийн боломжит хугацаа" гэдгийг хариу өгөх хугацааны талаар талууд харилцан тохиролцоогүй үед хэрэглэх ба хариу өгөх тухайн хэлбэрт шаардлагатай зохимжит хугацааг ойлгоно.**

Хариуг захидлаар, утсаар, нүүр тулан, хүнээр дамжуулах зэргээр өгөх хэлбэрээс нь хамааран уг хугацаа өөр өөр байх тул тухайн хэлбэрээр хариу өгөхөд шаардагдах хугацааг холбогдох хууль болон хууль тогтоомжийн актад тусгайлан заагаагүй бол шүүх харьцуулан жиших аргаар тодорхойлно.

**3.2. Энэ зүйлийн 43.3-т зааснаар хэлцлийг "бодит үйлдлээр хийгдсэн" гэж үзэхийн тулд хуулийн 42 дугаар зүйлийн 42.8-д заасан шаардлага хангагдсан байвал зохино.**

**3.3. Мөн зүйлийн 43.4-т заасан "хэлцлийн агуулгыг тодорхойлох боломжгүй" гэдэгт хэлцлийн зорилго, гол нөхцөл, талуудын эрх, үүрэг тодорхой бус байхыг ойлгоно.**

**Дөрөв. Болзол тавьж хийсэн болон биржийн хэлцлийн онцлогийг тодорхойлсон хуулийн 44-46 дугаар зүйлийн зарим заалтыг дараах байдлаар тайлбарласугай.**

**4.1. Хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2, 44.3-т заасан хойшлуулах болон өөрчлөгдөх болзолтойгоор хийгдсэн хэлцлүүдийн гол нөхцөл буюу ирээдүйд бий болох үйл явдал нь мөн зүйлийн 44.4-т зааснаар хэлцэл хийгч этгээдийн хүсэл зоригоос шалтгаалахгүй тул болзлын г.уулга хуулийн шаардлагад нийцээгүй, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харш бол хуулийн 45 дугаар зүйлийн 45.1-д зааснаар хэлцэл бүхэлдээ хүчин төгөлдөр бус байх ба харин тухайн үйл явдал болоогүй тохиолдолд хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д зааснаар зөвхөн болзол хүчин төгөлдөр бус болно.**

Болзол хүчин төгөлдөр бус болоход хуулийн 61 дүгээр зүйлд заасан хэлцлийн зарим хэсэг хүчин төгөлдөр бус болох шаардлага нэгэн адил хамаарна.



Тав. Хүчин төгөлдөр бус байх хэлцлийн үндэслэл, үр дагаврыг тодорхойлсон хуулийн 56 дугаар зүйлийн зарим заалтыг доорх байдлаар тайлбарласугай.

5.1.Хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.1.-д заасан “хууль зөрчсөн” гэж хуулийн хориглох хэм хэмжээг зөрчсөн, эсхүл хуулийн шаардлагыг хангаагүй хэлцэл хамаарах ба энэ зөрчил нь хэлцлийн эрх зүйн үндэслэлтэй байх зарчимд нийцэхгүй байхыг хэлнэ.

Тухайн төрлийн хэлцэл хийхэд хуулиар тогтоосон шаардлагыг зөрчсөн боловч агуулгын хувьд байж болох хэлцэл энэ зүйлийн зохицуулалтад хамаарахгүй.

5.2.Энэ зүйлийн 56.1.2-т заасан “дүр үзүүлэн хийсэн хэлцэл” нь тодорхой үр дүнд хүрэх зорилгоор бус, тухайн хэлцлийг хийх хүсэл зориг, эрмэлзэлгүйгээр, хэлцэл хийсэн зөвхөн гадаад илэрхийллийг бий болгохын тулд хийгддэг болно.

Тухайлбал, шүүхийн ирээдүйд гаргах шийдвэрээр төлбөр төлөх магадлалтай иргэн өөрийн эд хөрөнгийг төрөл садандаа бэлэглэсэн мэтээр өмчлөх эрхийг шилжүүлэх үр дагавар үүсгэхийн тулд биш харин ийнхүү хэлцэл хийсэн гадаад илрэлийг бий болгох зорилгоор хэлцэл хийх г.м.

5.3.Мөн зүйлийн 5.1.3-т заасан “өөр хэлцлийг халхавчлах зорилгоор хийсэн хэлцэл” гэдгийг тухайн хэлцлийг хийх хүсэл зориг, эрмэлзэлгүйгээр, уг хэлцлийн зөвхөн гадаад илэрхийллийг бий болгох зорилгыг агуулсан, халхавчилж болон халхавчлуулж буй хоёр хэлцэл хийгдсэнээр бий болдог дүр үзүүлсэн хэлцлийн нэг төрөл гэж ойлговол зохино.

Тухайлбал, талууд орон сууцыг худалдах-худалдан авах гэрээний дагуу шилжүүлж байгаа боловч татвараас зайлсхийхийн тулд хийсэн бэлэглэлийн гэрээг хүчин төгөлдөр бус гэж үзнэ. Хэлцэлд оролцогч талуудын хэн алин нь орон сууцыг үнэ төлбөргүйгээр, бэлэглэлийн журмаар шилжүүлэхийг хүсээгүй боловч бэлэглэлийн гэрээгээр өмчлөх эрх шилжүүлж буй байдлыг баталгаажуулж, улсын бүртгэлд бүртгүүлэхийн тулд хийсэн ба үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг бодит байдал дээр харгуу төлбөртэйгээр шилжүүлсэн байна. Бэлэглэлийн гэрээ нь худалдах-худалдан авах гэрээг халхавчлах зорилгоор хийж буй дүр үзүүлсэн хэлцэл болно.

5.4.Энэ зүйлийн 56.1.4-т заасан “үнэн санаанаасаа бус, хөнгөмсгөөр хандаж, түүнийгээ илэрнэ гэж урьдаас тооцож, тодорхой хүсэл зориг илэрхийлэн хийсэн хэлцэл” нь мөн дүр үзүүлсэн хэлцлийн нэг төрөл бөгөөд хэлцэл хийгчид уг хэлцлийг байгуулах хүсэл зориг угаас байгаагүй, уур уцаар, тоглоом хошигнол, өс хонзон зэрэг эрх зүйн бус үндэслэл буюу сэтгэлийн хөдлөлд тулгуурлан хүсэл зоригоо илэрхийлсэн байдал нь хожим зайлшгүй илэрнэ гэж үндэслэл муутайгаар тооцоолсон

субъектив санаанаас үүснэ.

Тухайлбал, гэрлэлтээ цуцлуулах талаар санал гаргасан эхнэрийгээ хашраах зорилгоор өөрийн хуваарьт хөрөнгөд хамаарах үе удам дамжиж ирсэн үнэт зүйлийг үл таних этгээдэд бэлэглэсэн нөхрийн хэлцэл хүчин төгөлдөр бус байна.

**5.5. Мөн зүйлийн 56.1.8-д заасан “хуулиар тогтоосон хэлбэрийг зөрчсөн”** гэдэг нь хуулийн 42 дугаар зүйлийн 42.10-т заасан шаардлагад хамааралтай ба энэхүү хэлбэрийн шаардлагад энгийн бичгийн хэлбэрээс гадна нотариатаар болон эрх бүхий этгээдээр гэрчлүүлэх, улсын бүртгэлд бүртгүүлэх хэлбэрийг мөн хамааруулан үзнэ.

Уг зүйл, хэсэгт заасан “**зохих этгээдийн зөвшөөрөлгүй хийсэн хэлцэл**” гэдэгт тухайн хэлцлийг хийхэд тодорхой этгээдийн зөвшөөрлийг авах хуулиар тогтоосон шаардлага зөрчигдсөн байхыг ойлгох бөгөөд уг хэлцэлд хуулийн 50 дугаар зүйлийн зохицуулалт хамаарна.

**5.6. Энэ зүйлийн 56.1.9-д заасан “хуулийн этгээд үйл ажиллагааныхаа үндсэн зорилгыг зөрчиж хийсэн хэлцэл”** гэдэгт хуулийн 4 дүгээр бүлгийн хоёрдугаар дэд бүлэгт заасан төрөлд хамаарах хуулийн этгээд нь байгуулагдсан болон үйл ажиллагаа эрхлэх болсон үндсэн шаардлага, шалтгаан, оршин тогтнож, үйл ажиллагааг үргэлжлүүлэн явуулах ач холбогдол, нөхцөл бололцоог үгүйсгэсэн хэлцэл хийхийг хамааруулан ойлгоно.

Хуулийн этгээд үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлөөс гадуур эсхүл улсын бүртгэлд бүртгүүлсэн үйл ажиллагааны чиглэлээс өөр ажиллагаа явуулах нь хууль зөрчсөн үйлдэл боловч энэ зохицуулалтад хамаарахгүй.

**5.7. Мөн зүйлийн 56.1.10-т заасан “хүчин төгөлдөр бус хэлцлийн үндсэн дээр хийсэн бусад хэлцэл”** гэдэгт хүчин төгөлдөр бус хэлцэлтэй шалтгаант нөхцөл байдлаар салшгүй холбогдсон, энэ хэлцэл хүчин төгөлдөр бус болсноор эрх зүйн үндэслэл нь үгүйсгэгдэх хэлцлийг хамааруулан ойлговол зохино.

Хүчин төгөлдөр бус хэлцлийн дараа хэлцлийн зүйл болох эд хөрөнгө болон эрхийн талаар хийсэн хэлцэл болгоныг хүчин төгөлдөр бус гэж үзэх үндэслэлийг уг заалтын зохицуулалт үүсгэхгүй.

**5.8. Энэ зүйлийн 56.3, 57 дугаар зүйлийн 57.3-г заасан “сонирхогч этгээд”** гэдэгт хэлцэл хийсэн тал эсхүл гуравдагч этгээдийн аль аль нь хамаарна.

**Зургаа. Хүчин төгөлдөр бус гэж тооцох хэлцлийн үндэслэл, үр дагаврыг тодорхойлсон хуулийн 57-60 дугаар зүйлийн зарим заалт, хэсгийг дараах байдлаар тайлбарласугай.**



6.1.Хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д заасан “хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцож болно” гэснийг хэлцлийг хүчин төгөлдөр бусд тооцуулахаар сонирхогч этгээд нэхэмжлэл гараагүй тохиолдолд тухайн хэлцлийг хүчин төгөлдөр бусд тооцох боломжгүй гэж ойлгоно.

6.2.Хуулиар тогтоосон хэлбэрийг зөрчсөн хэлцэл 56 дугаар зүйлийн 56.1.8-д зааснаар хүчин төгөлдөр бус байдаг бол гэрээгээр тохирсон хэлцлийн хэлбэрийг зөрчсөн хэлцлийг энэ зүйлийн 57.3-т зааснаар сонирхогч этгээдийн нэхэмжлэлээр хүчин төгөлдөр бусд тооцож болно.

6.3.Хуулийн 58 дугаар зүйлийн 58.6-д заасан “нэн даруй” гэдгийг тухайн тохиолдолд мэдэгдэх боломжтой ердийн хугацаанд гэж ойлгоно.

6.4.Хуулийн 60 дугаар зүйлийн 60.2-т заасан “аюул учирна гэж итгүүлж үнэмшүүлснийг” гэдэгт тухайн аюул учирч болзошгүй, бодит заналхийлэл байгаа нь тодорхой үйлдэл болон эс үйлдэхүйгээр илэрхийлэгдсэн байхыг хамааруулан үзнэ.

**Долоо. Хэлцэлд төлөөлөх, төлөөлөгчийн бүрэн эрхийг тогтоосон хуулийн 62 дугаар зүйлийн зарим заалтыг доорх байдлаар тайлбарласугай.**

7.1.Хуулийн 62 дугаар зүйлийн 62.2-т заасан “хэлцлийг төлөөлөгчөөр дамжуулан хийхийг хуулиар хориглосон”, “хэлцлийн шинж чанараас шалтгаалан хэлцэл хийгч заавал биечлэн хийвэл зохих” хэлцлүүдийг тодорхойлоход хэлцлээр хүлээх талуудын эрх, үүрэг, хэлцлийн гол нөхцөл, хэлцэлд оролцогч талын хувийн шинж чанар, хуулийн 210 дугаар зүйлд заасан шаардлагыг анхаарвал зохино.

7.2.Мөн зүйлийн 62.5-д заасан “итгэмжлэлийг шилжүүлэх” буюу давхар итгэмжлэх ажиллагааг зөвхөн үндсэн итгэмжлэлд тодорхой заасан эсхүл итгэмжлэл олгосон этгээдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах зайлшгүй шаардлага үүссэн бөгөөд энэ зүйлийн 62.7-д зааснаар тухайн этгээдэд мэдэгдсэний үндсэн дээр явуулна.

**ЕРӨНХИЙ ШҮҮГЧ  
ТАНХИМЫН ТЭРГҮҮН**

**С.БАТДЭЛГЭР  
Ц.АМАРСАЙХАН**

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн редвжн,  
Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: turim\_medeel@parliament.mn

Утас: 262420, 329612  
Хэвлэлийн хуудас 1 25

Индекс: 14003



Улсын Их Хурлын Тогмлын газрын өвчлэн хэргийн эмчлэл.  
Утас 329487